



Өрх толгойлсон эцэг, эх (тус тэтгэмжийг авсан)
хамрагдах боломжгүй

Хүүхэдтэй өрхөд олгох ОНЦГОЙ ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ

Хүүхэдтэй өрхийг дэмжиж ШИНЭЭР ТЭТГЭМЖ олгоно!

1. Тэтгэмжид хамрагдах хүн

Дараах ①②-т хамаарагдах хүн

(※ Өрх толгойлсон эцэг/эхийн тэтгэмжид хамрагдсан өрхөөс бусад)

① 2022 оны 3 сарын 31-ний байдлаар **18 нас хүрээгүй**
(хөгжлийн бэрхшээлтэй бол **20 нас хүрээгүй**)
хүүхэд өсгөж буй эцэг эх

(※ 2023 оны 2 сар дуусахаас өмнө төрсөн хүүхэд хамрагдах боломжтой.)

② {
■ 2022 онд оршин суугчийн албан татвар (нэг хүнд ногдох хувь) ногдуулаагүй хүн
■ 2022 оны 1 сарын 1-ээс хойш орлого нь огцом буурч, оршин суугчийн албан татвараас чөлөөлөгдөх хэмжээнд хүрсэн хүн

2. Тэтгэмжийн хэмжээ

Хүүхэд тутамд **50,000 иен**

■ Тэтгэмж олгоход, **хүсэлт гаргах шаардлагатай** болон **шаардлагагүй тохиолдол** байна. Зайлшгүй арын хуудсанд дахь тэтгэмжийн журмыг шалгана уу.

* Дэлгэрэнгүйг, дараах утаснаас лавлана уу.

■ Эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын яамны лавлах

0120-400-903 (Хүлээн авах: Ажлын өдөр 9:00~18:00)

Хүсэлт гаргах дэлгэрэнгүй мэдээллийг оршин суугаа хот, дүүрэг, орон нутгийн захиргааны 「Хүүхэдтэй өрхөд олгох онцгой тэтгэмж (өрх толгойлсон эцэг эхээс бусад) хариуцсан харилцах цонх」-ноос лавлана уу.

3. Тэтгэмж авах хүсэлт гаргах

I. 2022 оны 4 сард хүүхдийн тэтгэмж болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн халамжийн тэтгэмж авсан бөгөөд оршин суугчийн албан татвар ногдуулаагүй хүн

- ▶ Тэтгэмж авах **хүсэлт гаргах шаардлагагүйгээр** авах боломжтой.
- ▶ Хот, дүүрэг, орон нутгийн захиргаанаас аль болох түргэн хугацаанд 2022 оны 4 сард хүүхдийн тэтгэмж болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн халамжийн тэтгэмж олгодог данс руу шилжүүлнэ.


【Анхаарах зүйл】

- ※ Тэтгэмж авах хүсэлгүй бол тэтгэмж авахаас татгалзсан мэдэгдэл бичиж илгээнэ үү.
- ※ Хүүхдийн тэтгэмж болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн халамжийн тэтгэмж олгосон банкны данс хаагдсан болон ашиглах боломжгүй болсон тохиолдолд, данс өөрчлөх бүртгэл хийлгэнэ үү.

II. Дээрхээс бусад тохиолдолд

(Жишээ нь: Зөвхөн ахлах сургуулийн хүүхэдтэй хүн, орлого нь огцом буурсан хүн гэх мэт)

- ▶ Тэтгэмж авах **хүсэлт гаргах шаардлагатай**
- ▶ Өргөдөл дээрх мөнгө шилжүүлэх дансны мэдээллийг бөглөөд, шаардлагатай бичиг баримтын хамт оршин суугаа хот, дүүрэг, орон нутгийн захиргааны харилцах цонхонд тушаах, эсвэл шуудангаар илгээнэ үү.
- ▶ Хүсэлт гаргасан агуулгыг нягтлан үзэж, тэтгэмж авах болзлыг хангасан хүнд, бүртгэлтэй данс руу нь тэтгэмжийг шилжүүлэн олгоно.



“Хүүхэдтэй өрхөд олгох тэтгэмж”-ийг авахдаа **“Залиланд өртөж мөнгөө шилжүүлэх”** болон **“Хувийн мэдээллээ алдах”** зэргээс болгоомжилно уу.

Гэр болон ажлын байр луу тань хот, дүүрэг, орон нутгийн захиргаа болон эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын яамны ажилтны нэр барьсан сэжигтэй утас болон шуудан ирсэн тохиолдолд, оршин суугаа хот, дүүрэг, орон нутгийн захиргаа болон ойролцоох цагдаагийн хэлтэст мэдэгдэнэ үү. Мөн (#9110) цагдаагийн утсанд хандаж зөвлөгөө авна уу.